

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ¹

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-т “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тус тус заажээ.

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газраас баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг /цаашид “төсөл” гэх / боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Улсын Их Хурлын сонгууль явуулах эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилгоо.

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн:

1. Төсөл нь “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох” гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;

¹ Энэхүү үнэлгээг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн ЭНБД, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Ж.Ббулгансүрэн нар хамтран гүйцэтгэв.

2. Төсөлд тусгагдсан, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;

3. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь судална.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар өмнө нь тус тусдаа бие даасан хуулиар зохицуулагдаж байсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан.

Ийнхүү сонгуулийг зохион байгуулж явуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх болон хууль хэрэглээний хувьд олон төрлийн хүндрэл, бэрхшээл үүсч байсныг сонгууль зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагаанд хуулиар үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд, сонгогчид, нэр дэвшигчид, сонгуульд оролцсон нам эвслүүдээс удаа дараа илэрхийлж байсан. Иймд Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан сонгуулийн тогтолцоо, үндсэн зарчим, журмыг улам бүр тодорхой болгох, хуулийн тогтвортой байдлыг хангах, сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах зэргээр сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлагатай² гэж үзсэн байна.

Энэхүү төслийг Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан Улсын Их Хурал /цаашид “УИХ” гэх/-ын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулсан³ байна.

Дээрхээс дүгнэвэл, УИХ-ын сонгуулийн онцлогт нийцүүлэн энэхүү төслийг боловсруулсан болохыг харж болох бөгөөд уг төслийн зарим зохицуулалт уялдаа

² Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

³ Мөн тэнд.

холбоогүй, ойлгомжгүй, дутуу орхигдуулсан, давхардал, хийдэл, зөрчилтэй байгаа нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болох эрсдэлтэй байгааг өөрчлөн найруулах, бусад хуулиудтай уялдуулж, нийцүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Цаашид “МУИХСтХ” гэх/-ийн төслийн үзэл баримтлалаас үзвэл төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгоход оршиж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах;

- Улсын Их Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах;

- Сонгуулийг зохион байгуулж явуулах зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах. Иймд хуулийн төслийн дээрх зорилтуудтай холбогдох зүйл, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Сонгууль зохион байгуулж явуулах эрх зүйн орчныг сайжруулах.	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт.
2	Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах.	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг.
3	УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг.

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/ Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан талаарх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг тогтоох зэрэг зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх.	69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.” 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэг “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.”

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 90 зүйлтэй./

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 90 зүйлтэй./

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 3. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт; Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг; Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэг.	Практикт төслийн энэхүү заалтууд хэрэгжих боломжтой эсэхийг судлах. Хэрхэн хэрэгжүүлэх
3.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

3.1.1. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Сонгуулийг зохион байгуулж явуулах зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах” эхний зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авч судалсан болно:

<p>/Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт/ 9.9.Нөхөн сонгууль явуулах тухай шийдвэрийг Улсын Их Хурал тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 60 хоногийн дотор гаргана. 12.1.Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тойргийг аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг</p>
--

дэвсгэр, төвийг тогтооно. Тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл буюу зэргэлдээ байна.

13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

22.7.Энэ хуулийн 22.5-д зааснаас бусад сонгогчийн шилжилтийг аймаг болон нийслэл дотор хийхийг хориглоно.

26.3.1.тухайн сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх;

Энэхүү төслөөр Сонгуулийн тухай хууль /Цаашид “СтХ” гэх/-д заасан ойлгомжгүй, эрх зүйн хийдэл, зөрчилтэй хэд хэдэн заалтыг өөрчлөн найруулж, засаж сайжруулсан байна. Тухайлбал,

2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн явцад Сонгуулийн тухай хуулийн 22.5-д “Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг ... санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулж, тойргийн нутаг дэвсгэр, дугаар, төв, мандатын тоог тогтооно” гэж заасны дагуу сонгуулийн тойргийг байгуулсан.

Ийнхүү Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах явцад сонгогчид хоёр, гурван тойргийн дунд хуваагдсан 10 сум болон хил залгаа оршдоггүй хэд хэдэн тойрог байсан байна. Тухайлбал, Ховд аймагт хамгийн жижиг тойрог 11304 сонгогчтой. Улаанбаатар хотын хамгийн том тойрог болох Чингэлтэй дүүргийн 63 дугаар тойрог 41836 сонгогчтой. Мөн Увс аймгийн 33 дугаар тойрог нь зэргэлдээ биш гурван хэсэгт хуваагджээ. Улаанбаатар хотын гадна орших Багануур дүүрэг дөрвөн хэсэгт хуваагдаж, хэсэг тус бүр нь Баганууртай хил залгаа бус Сүхбаатар дүүргийн өөр өөр тойрогт хуваарилагдаж⁴ байжээ.

Энэхүү алдааг засахын тулд СтХ-д заасан дээрх зохицуулалтыг төслийн 12.1-д боловсронгуй болгон “Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө ... нутаг дэвсгэр, төвийг тогтооно. Тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд **нэгдмэл буюу зэргэлдээ байна**” гэж, мөн төслийн 12.2-т “Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэж болно” гэж тус тус өөрчлөн найруулсан нь 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн явцад сонгуулийн тойрог байгуулахад тулгамдаж байсан асуудлыг шийдвэрлэх боломжийг бий болгосон хэмээн үзэж болох юм.

Мөн төслийн 13.3-т “...нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна” гэж нэг хэсэгт байх сонгогчийн доод хязгаарыг тогтоож өгсөн нь СтХ-ийн 23.2-т заасан заалтыг боловсронгуй болгосон заалт болсон гэж үзэж байна.

Түүнчлэн, 2016 оны УИХ-ын сонгуульд нийт 1.912.901 сонгогч бүртгэгдсэн бөгөөд саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгуулийн хэсгийн хороодоос өөр газар байршиж байгаа сонгуулийн байгууллагын ажилтнууд, цэргийн албан хаагчид зэрэг хүмүүс хууль эрх зүйн хязгаарлалт болон бодит нөхцөл байдлын улмаас саналаа өгч чадахгүйд хүрч болзошгүй байна⁵ гэж 2016 оны УИХ-ын сонгуулийн урьдчилсан тайланд дурдсан байх бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд төслийн 22.7-д “Энэ хуулийн 22.5-д зааснаас бусад сонгогчийн шилжилтийг аймаг болон нийслэл дотор хийхийг хориглоно” гэж заасан бөгөөд 22.5-д “Сонгуулийн байгууллагын ажилтан, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан,

⁴ ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар, Сонгууль ажиглах хороо, Монгол Улс. УИХ-ын сонгууль 2016.6.26, Урьдчилсан тайлан 2016 оны 5 сарын 20-оос 6 сарын 14-ний өдөр.

⁵ Мөн тэнд.

мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн шийдвэрлэж болно” гэсэн зохицуулалтыг шинэчлэн найруулж тусгасан байна.

Мөн СтХ-ийн 124.3.1-д “санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй” тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзахаар хуульчилсан байна. Харин төслийн 26.3.1-д “тухайн сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн” нам, эвслийг бүртгэхээр тусгасан байна.

Ийнхүү төсөлд сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө гэж тусгасан нь СтХ-д заасан “...санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө” гэж хоногоор заан өгснөөс илүү хүн бүрд ойлгомжтой хугацааны хувьд хөтөлбөргүй байх боломжийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, УИХ-аас сонгуулийн санал авах өдрийг ээлжит сонгуулийн жил бүр өөр өөр өдөр тогтоох боломжтой бөгөөд санал авах өдрийг хэдний өдөр гэж тогтоосноос хамаарч санал авах өдрөөс 180 хоногийн өмнөх өдөр өөрчлөгдөх боломжтой бол “сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 1-ний өдөр” гэсэн нь өөрчлөгдөх боломжгүй юм.

СтХ-ийн 18.1-д “Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана” гэж заасныг төслийн 9.9-д боловсронгуй болгож “Нөхөн сонгууль явуулах тухай шийдвэрийг Улсын Их Хурал тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 60 хоногийн дотор гаргана” гэж зохицуулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, СтХ-д нөхөн сонгууль явуулах хугацааг зааж өгөөгүй байсныг төсөлд 60 хоногийн дотор гаргахаар тусгасан байна. Гэсэн хэдий ч төсөлд энэхүү заалтад “...60 хоногийн дотор гаргана” гэснийг “...60 хоногийн дотор товлон зарлана” гэж заасан нь илүү оновчтой хэмээн үзэж байна.

Энэ мэтчилэн төсөлд практикт хэрэгжүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлэх заалтууд олон байх боловч хэд хэдэн учир дутагдал, эрх зүйн хийдэл, зөрчилтэй заалтууд байна. Үүнийг дор дэлгэрүүлэн авч үзэх болно.

3.1.2. Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авч судалсан болно:

/Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг/

3.1.11."Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас" гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг.

45.2. Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно.

46 дугаар зүйл.Хууль бус сурталчилгааг хориглох

46.4.18.сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтад Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг ойлгохоор заасан. Өмнөх МУИХСтХ болон одоогийн СтХ-д цахим хуудасны тухай

ойлголтод ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд бүхий л төрлийн цахим хуудсыг ойлгох боломжтой байсан.

Дээрх зохицуулалттай уялдуулан төслийн 45.2, 46.4.18 дахь заалтад заасныг судлан үзвэл төслийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно” гэж зааснаас үзвэл сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсыг тодорхой тохиолдолд ашиглаж болохоор байна.

Гэтэл төслийн 46 дугаар зүйлийн 46.4.18-д “сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах” гэж заасан нь бусад хуудсаар аливаа хэлбэрээр сурталчилгаа явуулахыг хоригложээ. Өөрөөр хэлбэл, сурталчилгааны цахим хуудсыг тодорхойлсон тодорхойлолт болон түүнтэй хамааралтай заалтууд нь өөр хоорондоо зөрчилдсөн байж болзошгүй байна.

Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны цахим хуудаст олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсыг хамруулахгүй байхаар хуульчилсан нь үндэслэлтэй эсэхийг судлан үзвэл:

2016 оны 8 сард Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэнгээс хийсэн “Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа”-нд “Мэдээлэл авдаг гол эх сурвалж”⁶ гэсэн асуултад телевиз, интернет, нийгмийн сүлжээ гэсэн гурван гол эх сурвалж зонхилж байх бөгөөд “Улс төрийн талаарх мэдээлэл авахдаа нийгмийн аль сүлжээг та ашигладаг вэ?”⁷ гэх асуултад дийлэнх олонх буюу 43% нь Facebook гэж, 23% нь мэдээллийн цахим хуудас гэжээ. Үүнээс үзвэл, сонгогчид мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнээс илүү авдаг хандлага ажиглагдаж байна.

Нам, эвсэл, нэр дэвшигч нь сурталчилгааг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хуулиар хориглоогүй гэдэг нь чөлөөт байдлын зарчмыг баримтална гэсэн үг юм.⁸ Энд мөн “Чөлөөт байдлын зарчмын хязгаар” гэсэн ойлголт байдаг ба хязгааргүй чөлөөт байдал хаа ч үгүй. Тэр нь ямагт бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагддаг. Сурталчилгааг хуульд заасан хориг хязгаарлалтыг сахиж, ёс зүйтэй явуулах нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн өөрийгөө сонгогчдод зөвөөр ойлгуулж, тэдний талархлыг хүлээж, дэмжлэг авах боломж юм. Иймд сурталчилгаанд голлон анхаарах зүйл бол хуулийг зөрчихөөс болгоомжлох явдал⁹ болно. Хэдийгээр төсөлд олон нийтийн сүлжээг сонгуулийн сурталчилгааны цахим хуудсанд хамааруулахгүй байхаар зохицуулсан ч төслийн заалтууд нь хоорондоо зөрчилтэй байна.

Дээрхээс дүгнэвэл, нэг талаас олон нийтийн сүлжээ буюу Facebook, Twitter зэрэг хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байх нь мэдээллийн эмх замбараагүй, тогтворгүй урсгалаас сэргийлэх боловч нөгөө талаас сонгогчдын мэдээлэл авах хэлбэр

⁶ Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэн, Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа (УБ, 2016), Center for Insights in Survey Research, 74 дэх тал. https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf (Сүүлд үзсэн: 2019.01.03).

⁷ Мөн тэнд, 76 дахь тал.

⁸ Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 149 дэх тал.

⁹ Мөн тэнд.

нэлээд хязгаарлагдах тул энэхүү зохицуулалтыг сайтар судлан үзэж, зөрчилдөж буй зүйл заалтуудыг нэг мөр болгох өөрчлөх нь зүйтэй.

3.1.3. УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах зорилтын хүрээнд дараах заалтуудыг сонгон авлаа:

/Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг/

6 дугаар зүйл. Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

6.2. Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.

6.3. Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.

6.4. Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

6.5. Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.

6.6. Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална.

Төслийн 6 дугаар зүйлд “Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим”-ыг хуульчилсан бөгөөд өмнөх хууль болон одоогийн хуулиас ялгаатай нь тус зүйлд сонгуулийн үндсэн зарчим болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмыг хамтад нь тусгасан байна. Ингэхдээ зарим шаардлагатай зарчмыг орхигдуулсан байна.

Сонгуулийн хууль, эрх зүйн бусад хэм хэмжээг тогтоох, сахин биелүүлэх, хэрэглэхдээ нийтээр нэг мөр баримталдаг үндсэн эхлэл, сонгуулийн улс төр-эрх зүйн бодлогын тогтвортой үндсүүдийг сонгуулийн эрх зүйн зарчим¹⁰ гэдэг. Сонгуулийн эрх зүйн зарчим бол ардчиллын жам ёсыг бодитой тусгасан, заавал биелүүлэх, харилцан уялдаа холбоотой хэрэгжих арга хэрэглүүрийн нийлбэр цогц¹¹ юм.

1990-ээд оноос хойш ардчилсан хувьсгалын үр дүнд сонгуульд санал өгөх нь албадлага биш иргэний сайн дурын, хувийн үзэл бодлын асуудал болсон нь том ололт юм. Ийнхүү чөлөөт сонгууль жинхэнэ утгаараа Монголын нийгмийн практикт бий болов.¹² Хуучин тус тусдаа байсан хэдэн хуулийг халж, тэр үеийн гурван шатны (Улс, аймаг, сум /хот, район/-ын) Хурлыг “Ардын депутатуудын хурал” гэсэн нэрэнд “багцалж” “БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хууль” гэсэн төрөлжсөн нэг хууль гаргаж¹³ бүх шатны сонгуулийг зохицуулах болжээ. Тус хуулиар бэхжүүлсэн сонгуулийн тогтолцооны зарчим, журам өмнөхөөс үзэл баримтлалын эрс ялгаатай бөгөөд сонгогчид нийтийн, шууд, тэгш эрхийн зарчмаар, саналаа нууцаар гаргаж оролцох журам нэрийн хувьд давтагдсан боловч зарчмын шинэ агуулгатай болсон талаар Б.Чимид агсан цохон тэмдэглэжээ.

Сонгуулийн эрх зүйд сонгуулийн зарчмыг чиглэлээр нь 3 хуваадаг¹⁴ бөгөөд (а) сонгуулийг зохион байгуулж явуулах зарчим, (б) сонгуульд иргэдийн оролцооны зарчим, (в) иргэд, байгууллагын нийтээр баримтлах түгээмэл зарчим болно. Эдгээрийг төсөлд нэг зүйл болгон оруулахдаа зарим зарчмыг орхигдуулсан байна.

¹⁰ Мөн тэнд, 47 дахь тал.

¹¹ Мөн тэнд, 48 дахь тал.

¹² Д.Өлзийсайхан, Удирдлагын сэхээтэн (УБ, 2008), Бит Пресс, 6 дахь тал.

¹³ Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 32 дахь тал.

¹⁴ Мөн тэнд, 48 дахь тал.

Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 – 6.5 дахь хэсгийг үзвэл иргэдийн оролцооны буюу сонгуулийн үндсэн зарчимд бүх нийтийн, шууд сонгох, саналаа чөлөөтэй илэрхийлэх, саналаа нууцаар гаргах зарчмуудыг хуульчилсан. Хэдийгээр, тус зарчмууд нь өмнөх МУИХСтХ болон одоогийн СтХ-д тусгагдсантай адил боловч эдгээр хуульд бүгдэд нь “тэгш эрхийн зарчим”-ыг зохицуулаагүй нь Үндсэн хуулийн зохицуулалттай холбоотой.

Сонгуулийн тэгш эрхийн зарчмыг шинэ Үндсэн хуульд нэр зааж оруулаагүй ч аль ч улсад энэ зарчмыг сонгуулийн үндсэн зарчимд оруулж хэрэгжүүлэх арга механизмыг нь боловсронгуй болгосоор байна. Энэ зарчмын мөн чанар нь нэг сонгогч нэг удаагийн сонгуульд нэг л удаа саналаа өгөх, сонгогчид адил саналын эрхтэй байх явдлаар илэрхийлэгдэнэ.¹⁵

Дээр дурдсанчлан, БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хуульд “тэгш эрхийн зарчим” тусгагдсан байсан. Иймд одоогийн хуульд “тэгш эрхийн зарчим”-ыг хуульчлах нь зүйтэй талаар дараах үндэслэл байдаг:

Монгол Улсын Үндсэн хууль¹⁶-ийн Аравдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹⁷-ын 21 дүгээр зүйлийн 3-т “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” гэж заасан буюу сонгогчийн тэгш эрхийн зарчмыг тунхагласан.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт¹⁸-ын 25 дугаар зүйлийн (b)-д “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” хэмээн тэгш эрхийн зарчмыг тусгажээ.

Иймд төсөлд одоо тусгагдсан зарчмууд дээр нэмж “тэгш эрхийн үндсэн дээр оролцох” зарчмыг хуульчлах нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд нийцэх төдийгүй иргэний сонгох эрхийг бүрэн эхээр нь баталгаажуулах, сонгуулийн үндсэн зарчмын бүрдэл бүрэн хангагдах алхам болно.

Түүнчлэн, төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт “Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товросон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална” гэж сонгуулийг зохион байгуулах зарчмыг тусгажээ. Ингэхдээ өмнөх МУИХСтХ болон СтХ дахь “маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шийдвэрлэх”, “сонгогчийн эрх,

¹⁵ Монгол Улсын Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь, Олон Улсын бага хурал, (УБ, 2002), 31-32 дахь тал.

¹⁶ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1.

¹⁷ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ, 1946, <https://www.legalinfo.mn/law/details/1271>

¹⁸ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, НҮБ, 1966, <https://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257>

сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх”, “энгийн ойлгомжтой байх” зэрэг зарчмуудыг хуульчлаагүй орхигдуулсан байна.

Өөрөөр хэлбэл, төсөлд нийтээр баримтлах түгээмэл зарчим болох хууль дээдлэх болон шударга ёсны зарчмыг хуульчилсан нь сайшаалтай хэдий ч сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмуудыг орхигдуулжээ.

Өдгөө сонгуулийн эрх зүйн зарчмуудыг өргөтгөн авч үзэх хандлага бий болсон бөгөөд зарчмууд зөвхөн иргэдийн сонгуульд оролцох үзэл хандлагыг төдийгүй ард түмэн засгийн эрхээ хэрэгжүүлэхэд засаг төрөөс үр нөлөөтэй, шийдвэрлэгч чанартай оролцуулах нөхцөлийг хангах үүрэг, ардчилсан ёсны арга хэрэглүүрийг багтаах¹⁹ тул дээрх орхигдуулсан зарчмуудыг хуульчлах нь зүйтэй.

3.2. Практикт хэрэгжих боломж

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төслийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна”, 69.5 дахь хэсэг “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэсэн зүйл, заалтыг тус тус сонгон авч үнэлэлт өгөхийг зорилоо. Тус шалгуур үзүүлэлтээр сонгон авсан зохицуулалтын хүрээнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх гэсэн хоёр асуултад хариулт өгөхийг эрмэлзлээ.

/Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэг/

69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.”

69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэг “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.”

1. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4-т “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна” гэж, 69.5-д “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж тус тус заасан байна. Уг заалтаас харахад санал авах байранд тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангах зохицуулалтыг хийх субъект нь тодорхойгүй байна.

Бүх нийтийн сонгууль, санал асуулга зохион байгуулах нь аливаа улсын хувьд их хэмжээний төсөв хөрөнгө шаардсан, сайн зохион байгуулж хэрэгжүүлбэл зохих үндэсний хэмжээний томоохон арга хэмжээ юм. Санал өгөх байр хэдийг бэлтгэх, хэдэн хүн

¹⁹ Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 47 дахь тал.

ажиллуулах, ямар материал шаардлагатай зэргийг нарийвчлан тооцож гаргах нь зардлаа бууруулах боломжийг бүрдүүлдэг. Мөн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тогтоож, зохион байгуулалтын өндөр түвшинд сайтар анхаарч бүх нийтийг хамруулан сонгуулийг зохион байгуулах нь зүйтэй.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хуулиараа хүлээн зөвшөөрсөн байдаг.

Сүүлд явагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн явцад олон улсын сонгуулийн ажиглах хорооноос гаргасан урьдчилсан дүгнэлтэд "...СЕХ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахын тулд нэлээдгүй хүчин чармайлт гаргасан бөгөөд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлуудыг тусгажээ. Сонгуулийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан хэдий ч санал авах олон байр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байв²⁰ хэмээн дурджээ.

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.²¹ Гэвч зарим төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй сонгогчдын санал өгөх эрхийг эрх зүйн чадамжгүй гэх өргөн хүрээтэй ойлголтод хамаатуулан хязгаарлаж байгаа нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зарчим, үзэл санаанд нийцэхгүй байна. АН болон МАН-аас нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгажээ. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ.²²

СтХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно. Түүнчлэн санал авах байруудыг харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Олон улсын ажиглагчдын хорооны очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдсөн байсан. Хэдийгээр СтХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл

²⁰ Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26-ны өдөр. Дэлгэрэнгүйг <https://www.osce.org/mn/odihr/327166?download=true> үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2019.1.14).

²¹ 2009 оноос хойш Монгол Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид (ХБХЭТК) нэгдэн орсон. Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхахыг зөвхөн ерөнхий зарчмаар хангаж, харин баталгаатай арга хэмжээгээр зааварчлаагүй байдаг. 2016 оны ХБХЭТХ болон бусад холбогдох хуулийн заалтуудаар улс төрийн оролцоонд хамаарах зохих хамгаалалт, нөхцөлөөр ханган өгсөн.

²² Мөн тэнд.

боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв.²³

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудын тооцоолсноор хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж саналаа өгөхийн оронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг илүүд үздэг ажээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн хайрцгаар саналаа өгөх боломжийг олгож буй нь иргэний болон сонгуулийн эрхийг нь хангаж байгаа ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй²⁴ гэж ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хязгаарлагдмал хорооноос урьдчилан гаргасан дүгнэлтэд дурджээ.

Түүнчлэн, төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан дээрх заалтуудыг практикт хэрэгжүүлэх субъект нь тодорхойгүй байна.

2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх.

Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2009 оноос нэгдэн орсон. Мөн Үндсэн хуулиндаа “ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн ерөнхий зарчмыг тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд тусгайлан заалт байдаггүй. 2016 оны 2 дугаар сард батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэдний нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30.1-д “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж заасан байдаг. Харин энэхүү төслийн 14.18-д “Сонгуулийн хороог аюулгүй байдал хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна” гэж заасан нь тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг яаж, ямар субъект хариуцах талаарх зохицуулалтыг орхигдуулж ойлгомжгүй байдлыг үүсгээд байна. Иймд төслийн 69.4, 69.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэх, тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах субъектыг тодорхой болгох нь зүйтэй юм.

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй

²³ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас тооцоолж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж санал өгснөөс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхийг хүсжээ. ХБХЭТК-ийн 29 дугаар зүйлд улс орнуудад “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”- ыг зөвлөсөн байдаг.

²⁴ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6 сарын 26 болон 7 сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан, 25 дахь тал. (Сүүлд үзсэн: 2019.1.14).

[Дэлгэрэнгүйг <https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true> үзнэ үү.](https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true)

болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.²⁵

СтХ-д ч мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхээ эдлэх боломжийг хөнгөвчлөн, санал авах байр нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгах, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заажээ. СЕХ нь эдгээр шаардлагыг ханган биелүүлсэн боловч хөдөө орон нутгийн дэд бүтцийн нь санал авах байруудад орох боломж нөхцөлийг хязгаарлах магадлалтай байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид нь оршин суугаа хаягаараа зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар санал өгөх хүсэлт гаргах боломжтой.²⁶

Хэдийгээр харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа өгөх байдлыг хөнгөвчилсэн сайшаалтай арга хэмжээ хийгдсэн байсан ч ЕАБХАБ/АИХЭГ-ын сонгуулийн ажиглах хорооны ажиглалт хийсэн санал авах байруудын 35 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг орох боломжоор хангасан²⁷ байжээ.

Дээрхээс дүгнэвэл, төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан заалтууд нь практикт бүрэн хэрэгждэггүй зохицуулалт болохыг дээр дурдсан сонгуулийн судалгааны тайлангуудаас харж болох юм. Иймээс энэхүү зохицуулалтуудыг практикт бүрэн хэрэгжүүлэхийн тулд цаашид анхаарвал зохих хэд хэдэн асуудал байгааг судлан үзэж төсөлд тусгах нь зүйтэй болов уу. Тухайлбал, энэхүү заалтыг хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгох, түүнчлэн сонгуулийн санал авах байрыг тэргэнцэртэй иргэдийг орох боломжтой байдлыг харгалзан сонгох, эсхүл санал авах өдрөөс өмнө шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох субъектэд даалгах нь зүйтэй.

2020 оны УИХ-ын сонгуульд тэргэнцэртэй иргэдийн сонгох эрхийн хангах үүднээс өмнөх хуулиудад ч бэлэгдлийн төдий байдлаар хуульчлагдаж ирсэн энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

3.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 4. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	“Нэн даруй” гэсэн нэр томъёо бичигдсэн төслийн зохицуулалтууд: 6.10, 18.2.3, 19.11, 19.14, 46.14, 68.8, 76.4, 78.1.2, 78.5.2, 78.16, 78.17, 80.1 дэх хэсэг.	Хуулийн төсөлд “нэн даруй” хэрэгжүүлэхээр заасан 12 заалт байх бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудыг үзвэл хууль, түүний зохицуулалтаас хамаарч “нэн даруй” гэдгийг ойлгох хугацаа өөр байна. Тухайлбал, Иргэний хуульд заасан “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх	Явуулах үйл ажиллагааны төрлөөс хамаарч “нэн даруй” гэдгийг өөр өөрөөр ойлгон, хэрэглэж байх тул хуульд аутентик тайлбар хийх замаар

²⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №9.

²⁶ ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХХ, Монгол Улсын Ерөнхийлөгч сонгууль 2017 оны 6 сарын 26-ны өдөр, Урьдчилсан тайлан 2017 оны 5 сарын 23-ны өдөр

²⁷ Мөн тэнд.

		боломжтой ердийн хугацаанд ²⁸ ойлгохоор байгаа бол Прокурорын /хуучин/ тухай хуульд заасан “нэн даруй” гэдгийг 24 цагийн дотор ²⁹ гэж ойлгохоор байна.	тайлбарлах.
2	Төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.”	Хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
3	Төслийн 6 дугаар зүйлийн 6.8-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална.”	Иргэний хуульд хугацаа тоолох тухай зарчим тусгагдаагүй байхад Иргэний хуульд заасан зарчмыг баримтална гэсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
4	Төслийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.”	Төслийн энэхүү зохицуулалт нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан байна. Өөрөөр хэлбэл, сонгох, сонгогдох эрх тусдаа байх бөгөөд сонгууль зохион байгуулах, сонгуулийн төв хорооны ил тод байдалтай хамааралгүй юм.	Сонгууль зохион байгуулах ил тод байдлыг хангах гэж ойлголтыг нэг мөр болгох.
5	Төслийн 6 дугаар зүйлийн 6.12-т “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага,	Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллагын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Ойлголтыг нэг мөр болгох.

²⁸ Улсын дээд шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.6.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, <https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178> (Сүүлд үзсэн: 2018.12.26).

²⁹ Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол (2003.2.20.) “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, <https://www.legalinfo.mn/law/details/603> (Сүүлд үзсэн: 2018.12.26).

	<p>албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх, сонгогчдод сонгуулийн мэдлэг олгох, эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.”</p>		
6	<p>Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт.</p>	<p>Төслийн 10.1.14-т “энэ хуулийн 48.2-т заасан мөнгөн урамшуулал” гэж заасан бөгөөд төслийн 48.2-т “ Сонгуулийн зардал нь дараах хөрөнгөөс бүрдэнэ: 48.2.1. хандив; 48.2.2. намын өөрийн хөрөнгө; 48.2.3. нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө” гэж заасан байхад уг төслийн 10.1.4-т “энэ хуулийн 48.2-т заасан мөнгөн урамшууллын зардал” хэмээн тусгаснаас төслийн 48.2 дахь заалт нь мөнгөн урамшууллын зардал мэтээр ойлгогдож байгаа энэхүү заалт ойлгомжгүй болохыг харуулж байна.</p>	<p>Иймд энэхүү заалтад өөрчлөлт оруулах.</p>

7	<p>Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг.</p>	<p>Төслийн дээрх заалтууд нь практикт хэрэгжихэд ойлгомжгүй байдлыг бий болгохоор байна. Тухайлбал, төслийн 16.1-д “ Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтаас үзвэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн даргаас гадна таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор заасан учир сонгуулийн хороог зургаан /тэгш тоотой/ гишүүнтэйгээр байгуулж болохоор харагдаж байна.</p> <p>2005 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж,</p> <p>2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан байсан нь аливаа шийдвэр гаргах тохиолдолд санал тэнцэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс сонгуулийн хороог сондгой тооны гишүүнтэйгээр байгуулж байсан байна. Тиймээс төсөлд заасан дээрх зохицуулалтад өмнө дагаж мөрдөж байсан хуулиудын нэг адил асуудал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг мөр, ойлгомжтой байлгах үүднээс өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.</p>	<p>Практикт сонгуулийн хороог байгуулахдаа тав эсхүл долоо гишүүнтэйгээр буюу сондгой тооны гишүүнтэйгээр байгуулдаг байх тул төслийн дээрх зохицуулалтыг маргаан дагуулахгүй байлгах үүднээс “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, “зургаагаас найман гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах шаардлагатай.</p>
8	<p>Төслийн 19 дүгээр зүйлийн 19.10-т “Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны</p>	<p>Урьдчилан мэдэгдэх хугацаа тодорхойгүй байна.</p>	<p>Урьдчилан мэдэгдэх хугацааг тодорхой болгох.</p>

	үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.”		
9	Төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, сонгогчдийн нэрсийн жагсаалт болон сонгогч шилжих, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.”	Бүлэг болоод зүйлийн гарчигт “Сонгогчдын нэрийн жагсаалт” гэж бичигдсэн атал зүйлийн доторх хэсэгт “сонгогчдын нэрийн жагсаалт”, “сонгогчдын нэрсийн жагсаалт” гэсэн хоёр янзаар бичигдсэн байна.	Тус нэр томъёог нэг мөр болгох.
10	21 дүгээр зүйлийн 21.1-д “Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт	Төслийн энэхүү зохицуулалтаас үзвэл аливаа шалтгааны улмаас санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гомдол гаргаж чадаагүй сонгогчийн тухайд сонгох эрх нь зөрчигдөхөөр харагдаж байна. Тухайлбал, төслийн 21.1-д заасан үндэслэлээр гомдол гаргах иргэн санал авах өдрөөс 10 хоногийн өмнө энэ тухай мэдсэн тохиолдолд гомдол гаргах эрхгүй болох бөгөөд цаашилбал сонгох эрхээ эдлэх боломжгүй болж байна. ³⁰	Гомдол гаргах хугацаа боломжит хугацаа мөн эсэхийг дахин нягтлах.

³⁰ Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайланд “Сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын

	хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.”		
11	Төслийн 46 дугаар зүйлийн 46.14-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 46.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан байна. Төслийн 46 дугаар зүйлийн 46.15-д “Шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 37.1, 45, 46.1.8, 46.6-д хяналт тавьж ажиллана.”	Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор ... тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ” гэж заасан. Харин төслийн холбогдох заалтуудаас үзвэл, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулийн зохицуулалтад хяналт тавихаар ойлгогдож байна.	“... 46.9 дэх хэсэгт заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах” гэж буюу “...37.1, 45, 46.1.8, 46.6 дахь хэсгийн заалтуудын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллах” гэж өөрчлөх.
12	Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг “	Төслийн 46 дугаар зүйлд “Хууль бус сурталчилгааг хориглох” тухай зохицуулалтуудыг тусгасан боловч төслийн 46.3-т “Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно” гэж заасан нь хориглосон заалтын хэсэгт “зөвшөөрсөн” зохицуулалтыг тусгасан нь төслийн бусад заалтуудын уялдаа холбоо, утга найруулгыг алдагдагдуулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Энэхүү зохицуулалтыг зохих хэсэгт нь тусгах.
13	Төслийн 73 дугаар зүйлийн 73.17 дахь хэсэг.	Төслийн уг заалтад “...14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна” гэж заасан нь Зөрчлийн тухай	Иймд төслийн уг заалтад “баривчлах

төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэлтэй байлаа” гэж дурдаж байжээ.

Дэлгэрэнгүйг <https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true> үзнэ үү. (Сүүлд үзсэн огноо: 2019.1.2).

		хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.1-д “баривчлах шийтгэл” гэж зааснаас өөрөөр ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, төсөлд “баривчлах захиргааны шийтгэл” гэж заасан нь захиргаанаас баривчлах шийтгэл оногдуулах мэтээр ойлгогдож байна.	захиргааны шийтгэл” гэж заасныг “баривчлах шийтгэл” гэж өөрчлөн найруулах.
	Төслийн 75 дугаар зүйлийн 75.2-т “Ажиглагч дараах эрх эдэлнэ: 75.2.2.санал авах, үйл ажиллагааг ажиглах”	Төсөл дэх ажиглагчийн эдлэх эрхийг заасан зохицуулалт болох 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн 75.2.2-т “санал авах, үйл ажиллагааг ажиглах” хэмээн хооронд таслал тавьснаар ажиглагч нь үйл ажиллагааг ажиглахаас гадна санал авах эрхтэй гэж ойлгогдохоор байна.	Хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах.
14	Итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэх нэр томьёо орсон төслийн зохицуулалтууд: Төслийн 20.10, 21.8, 22.2, 22.4, 70.7, 72.9, 10.2.3, 20.11, 20.12, 21.2, 21.4, 22.4, 22.6, 70.2, 72.1.5, 72.4, 78.10 дахь хэсэг.	Төслийн дурдсан заалтуудад итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэж нэг хүнд хамаарах ойлголтыг хоёр өөр байдлаар нэрлэн, төсөлд тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна. ³¹	Нэр томьёог нэг мөр болгож, хоёрдмол утгагүй байхаар томьёолох.

Хүснэгт 5. Итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэж хоёр өөр байдлаар бичигдсэн төслийн зүйл заалт

№	Итгэмжилсэн ажилтан	Итгэмжлэгдсэн ажилтан
1	20.10 дахь хэсэг	20.10 дахь хэсэг
2	21.8 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/	10.2.3 дахь заалт
3	22.2 дахь хэсэг /улсын бүртгэлийн/	20.11 дэх хэсэг
4	22.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн/	20.12 дахь хэсэг
5	70.7 дахь хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/	21.2 дахь хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/
6	72.9 дэх хэсэг /иргэний бүртгэлийн/	21.4 дэх хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/
7		22.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн/
8		22.6 дахь хэсэг /улсын бүртгэлийн/

³¹ Дэлгэрэнгүйг хүснэгт 5-аас үзнэ үү.

9		70.2 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/
10		72.1.5 дахь заалт /улсын бүртгэлийн/
11		72.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын/
12		78.10 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн³² 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 6. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн бүтэц, хэлбэр	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Төслийн 42 дугаар зүйлийн 42.5-д “Энэ хуулийн 42.3 дахь заалтад шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллага хамаарахгүй” гэж заасны “42.3 дахь заалтад” гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.13-т заасны дагуу “42.3 дахь хэсэгт” гэж өөрчлөх.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, хорин таван нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор тусгажээ. Энэхүү ойлголт нь хоёр өөр субъектын /нэр дэвшигч, сонгогч/ талаар тодорхойлж байгаа тул тусад нь зохицуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, сонгох эрх бүхий иргэний тухайд санал авах өдөр буюу түүнээс өмнө хуульд заасан насанд хүрсэн байх зохицуулалт нь хүнийг сонгох эрхээ эдлэх боломжоор хангасан хуулийн төслийн зорилгод нийцсэн зохицуулалт болсон

³² Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015, №25.

	<p>бол нэр дэвшиж буй иргэний тухайд “хорин таван нас хүрсэн” байх тухай зохицуулалт нь сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор заажээ. Төслийн дээрх 3.1.7-д зааснаас үзвэл “Сонгуулийн санал авах өдөр 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн УИХ-ын сонгуульд нэр дэвших эрхтэй бөгөөд нэр дэвшигчээр бүртгүүлэх үедээ 24 настай байж болно гэж ойлгогдож байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “хорин таван нас хүрсэн” гэж заажээ.</p> <p>Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуульд оролцогч иргэний сонгогдох эрх тухайн насанд хүрснээр бий болох учиртай. Энэ ч утгаараа тус заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтад нийцэж байгаа эсэх нь учир дутагдалтай байна. Иймд “арван найм, хорин таван нас хүрсэн” гэсэн ойлголтыг тусад нь субъектыг тодорхой заан зохицуулах шаардлагатай.</p>
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэд хэдэн тохиолдол илэрсэн бөгөөд энэ талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

<p>оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	
<p>29.1.9. Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.</p>	
<p>30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;</p>	<p>Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.</p>
<p>30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>

30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;

Төслийн 6 дугаар зүйлийн 6.10-т "...нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд нь..." гэснийг "...нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргасан этгээд нь" гэж,
Төслийн 4.4, 19.1, 28.4-т "...олонхийн..." гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "олонхын" гэж,
Төслийн 9.10-т "Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын ..." гэж заасны "зургаадугаар" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "зургадугаар" гэж,

Төслийн 9.6-д "... тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсаны дараа..." гэж заасны "гарсаны" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "гарсны" гэж,

Төслийн 10.1.3-т "сэлбэг хэрэгсэл, програм хангамж...", 10.2.1-д "...техник хэрэгсэл, сэлбэг, програм хангамж...", 10.7-д "...техник хэрэгсэл, програм хангамж..." гэж тус тус заасны "програм" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "программ" гэж,

Төслийн 33.1-д "сурталчилах" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "сурталчлах" гэж,

Төслийн 20.1, 20.21, 20.22, 20.23, 21.6, 21.7, 21.8, 75.2.10, 85.4-т "сонгогчдийн" гэдгийг "сонгогчдын" гэж,

Төслийн 24.1.3-т, 24.8-д "...бүрт..." гэж заасны "бүрт" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "бүрд" гэж,

Төслийн 27.4.3-т "эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байх" гэдгийг "хүлээлгээгүй" гэдгийг "хүлээгээгүй" гэж,

Төслийн 41.1, 41.2-т "тэмдэгийг" гэж бичсэнийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "тэмдгийг" гэж,

Төслийн 43.3-т "Ухуулгын байрыг доор дурдсан зорилгоор ажиллуулна" гэсний "доор" гэдгийг "дор" гэж,

Төслийн 44.22-т "...цуцлана" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "цуцална" гэж,

Төслийн 46.14-т "...хяналт тавиж" гэсний "тавиж" гэдгийг Монгол хэлний журамласан толь бичигт "тавьж" гэж,

Төслийн 88.1-д "... хууль заасан харъяалал" гэж заасны "харъяалал" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "харьяалал" гэж тус тус бичсэн байх тул дээр дурдсан үгнүүдийг засаж бичих.

Төслийн 3.1.7-д "Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн" гэсний "хорин" гэдгийг "Хорин" гэж бичих.

Төслийн 9.10, 20.22-т "...сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан байна. "Сонгуулийн ерөнхий хороо" гэдэг нь оноосон нэр учир том үсгээр эхэлж бичнэ. "Сонгуулийн ерөнхий хороо" болгож засах.

Төслийн 20.3-т "...сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн..." гэж заасны "Иргэдийн" гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэж заасан байх тул "иргэдийн" болгож засах.

Төслийн 39.4-т "...сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн..." гэж заасны "хурлын" гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэж заасан байх тул "Хурлын" болгож засах.

Төслийн 6.13-т "...6.12-д..." гэснийг "...6.12-т" гэж;

Төслийн 6.14-т, 6.15-д "...6.4-д..." гэснийг "...6.4-т" гэж;

	<p>Төслийн 8.3-т "...8.1-м..." гэснийг "...8.1-д" гэж; Төслийн 13.2-т "...13.1-м..." гэснийг "...13.1-д" гэж; Төслийн 19.23-т "...18.14-д..." гэснийг "...18.14-м" гэж; Төслийн 22.7-д "...22.5-м..." гэснийг "...22.5-д" гэж; Төслийн 22.8-д "...22.1-22.7-м...22.7-м" гэснийг "...22.1-22.7-д, 22.7-д" гэж; Төслийн 26.4-т "...26.3-д..." гэснийг "...26.3-м" гэж; Төслийн 39.14-т "...39.11-м..." гэснийг "...39.11-д" гэж, Төслийн 43.4-т "...43.1-м..." гэснийг "...43.1-д" гэж, Төслийн 44.11-д "...44.10-д..." гэснийг "...44.10-м" гэж, Төслийн 45.5-д "...45.4-д..." гэснийг "...45.4-м" гэж, Төслийн 45.6-д "...45.4-д..." гэснийг "...45.4-м" гэж, Төслийн 53.9-д "...53.4-д..." гэснийг "...53.4-м" гэж, Төслийн 58.5-д "...58.3-д..." гэснийг "...58.3-м" гэж, Төслийн 63.6-д "...63.3-д..." гэснийг "...63.3-м" гэж, Төслийн 64.5-д "...64.4-д..." гэснийг "...64.4-м" гэж, Төслийн 65.4-т "...65.1-м..." гэснийг "...65.1-д" гэж, Төслийн 70.3-т "...70.1.1-м..." гэснийг "...70.1.1-д" гэж, Төслийн 70.4-т "...70.1.1-м..." гэснийг "...70.1.1-д" гэж, Төслийн 70.17-д "...70.4-д..." гэснийг "...70.4-м" гэж, Төслийн 72.14-т "...72.12-д..." гэснийг "...72.12-м" гэж, Төслийн 79.6-д "...79.2-д..." гэснийг "...79.2-м" гэж, Төслийн 82.2, 82.3-т "...58.3-д..." гэснийг "...58.3-м" гэж, Төслийн 36.9-д "50-аас доошгүй" гэснийг "50-иас доошгүй" гэж тус тус өөрчлөн бичих. Төслийн 10.5-д "10.2, 10.3, 10.4 дэх хэсэгт" гэснийг "10.2-10.4-т" гэж өөрчлөх. Төслийн 6.7-д "Сонгуулийн хугацааг хугацааг санал авах өдөртэй..." гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "хугацааг" гэдэг үгийг хасах. Төслийн 6.10-т "Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд нь нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд албан ёсоор мэдээлнэ" гэж заасны мөрдөхөөр "гаргасан" гэж давхардаж бичигдсэнийг хасах. Төслийн 10.3.1-д "... санал авах үеийн хамгаалалт, хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал" гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "хамгаалалт" гэдэг үгийг хасах. Төслийн 73.2-т "тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний баримт бичиг, эсхүл хуурамч баримт бичиг ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох" гэж заасны зохицуулалтад давхардан бичигдсэн "эсхүл" гэдэг үгийг хасах.</p>
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах

асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 7. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх тул хуулийн төслийн 5 дугаар зүйл, 9 дүгээр зүйл нийцэхгүй байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн үзэл баримтлалд “сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлагатай байна гэж үзэн хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа СтХ-ийн ерөнхий зарчмыг баримтлан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан хуультай болох үүднээс боловсруулсан гэж” тусгасны дагуу энэхүү төслийн нэр нь хуулийн төсөл хийгээд төслийн үзэл баримтлалын агуулгатай нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	<p>Төслийн 37 дугаар зүйлийн 37.7-д “Энэ хуулийн 37.1, 37.4-д заасныг зөрчсөн нь радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно.” гэж, 46 дугаар зүйлийн 46.14-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 46.9-д хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан байна.</p> <p>Гэтэл Харилцаа холбооны тухай хууль³³ /цаашид “ХХТХ” гэх/- д “зогсоох” гэсэн үгийг голцхүү хэрэглэгч, үйлчлэгчид хамааруулан ойлгохоор хуульчилсан. Харин ХХЗХ-ны үйл ажиллагаанд “түдгэлзүүлэх”, “хүчингүй болгох” гэсэн үгийг хамааруулан ойлгохоор тусгажээ.</p> <p>Төслийн 44 дүгээр зүйлийн 44.22-т телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулсан бөгөөд ХХТХ-д “гэрээ цуцлах” гэсэн ойлголт байхаас тусгай зөвшөөрлийг цуцлах тухай нэр томъёо байхгүй, дээр дурдсанчлан “хүчингүй болгох” гэсэн нэршлээр илэрхийлдэг. Иймд “цуцална” гэснийг “хүчингүй болгоно” гэж өөрчлөн найруулах шаардлагатай.</p>
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	<p>МУИХТХ-тай зөрчилдөж буй талаар</p> <p>Төслийн 9 дүгээр зүйлийн 6-д “Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их Хурал ажлын арван өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн /цаашид МУИХТХ гэх/ 30 дугаар зүйлийн 30.5-т “...Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” хэмээн заасан заалттай зөрчилдөхөөр байна.</p> <p>МУИХТХ болон төслийн дээрх зохицуулалтууд нь нэг утга санааг илэрхийлж байгаа боловч МУИХТХ-ийн 30 дугаар зүйлийн</p>

³³ Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43

30.5-т онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлахаар” харин төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “... тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их хурал ажлын 10 өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлахаар” тусгажээ. Ийнхүү МУИХТХ-д сонгуулийг ажлын 7 хоногт багтаан товлон зарлахаар тусгасан байхад энэхүү төсөлд ажлын 10 өдөрт багтаан сонгуулийг товлон зарлахаар тусгасан дээрх хуулийн заалттай зөрчилдөхөөр байна. Иймд төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасан энэхүү заалтыг МУИХТХ-тай нийцүүлж, өөрчлөн найруулах нь зүйтэй.

Зөрчлийн тухай хуультай зөрчилдөж буй талаар
Төслийн 46.1.4-т “бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах”-ыг хориглохоор заасан бөгөөд 46.13-т “Энэ хуулийн 46.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох”-оор заасан бөгөөд энэхүү заалтад заасан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараах нь Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан заасан “Гүтгэх” зөрчлийн шинжийг мөн агуулж байна. Энэ тохиолдолд хэрэв төсөлд зааснаар хариуцлага оногдуулбал иргэнийг 320.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3.520.000-5.120.000 төгрөгөөс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг 1.920.000-2.560.000 төгрөгөөр тус тус торгохоор байна.
Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар дээр зөрчлийг үйлдсэн хүнийг 2.000.000 төргөрөөр, хуулийн этгээдийн 20.000.000 төгрөгөөр торгохоор хуульчилсан байна. Иймд төслийн 46.1-д заасан бусад заалтуудаас мөн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой заалтуудыг хуулийн давхардал үүсгэхгүй байлгах үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр зохицуулах нь зүйтэй.

Төрийн албаны тухай хуультай зөрчилдөж байгаа талаар
Төслийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.21 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.24 дэх хэсэг, 87 дугаар зүйлийн 87.4 дэх хэсэгт заасан зохицуулалтууд нь 2019 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.4-т “...төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” гэж заасантай зөрчилдөхөөр байна. Учир нь төслийн дээрх заалтуудад “төрийн албанд нэг жил, ... хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах”-аар тусгасан нь Төрийн албаны тухай хуулийн заалттай зөрчилдөж байна хэмээн үзэх үндэслэлтэй байна.

	<p>Төслийн 20.6-д "... улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн тавдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ" гэж заасан бөгөөд 20.6.6-д "цагдаагийн байгууллага санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг" гэж тус тус заасан нь хоорондоо зөрчилтэй байна.</p> <p>Төслийн 20.8-д "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.4, 20.6.5, 20.6.6-д заасны дагуу ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн тухайн цэргийн анги, нэгтгэл хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах" тухай тусгасан.</p> <p>Төслийн 21.3-т "Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно" гэж, 21.5-т "Санал авах өдрийг хүртэлх долоо хоногийн хугацаанд энэ хуулийн 21.2-т заасан ажиллагааг хийхийг хориглоно" гэж тус тус заасан нь 20.8-д заасан зохицуулалт нь зөрчилдөхөөр байна.</p> <p>Төслийн 70.1-д "Дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр 09:00-20:00 цагийн хооронд авна:</p> <p>70.1.3-т "Зөрчлийн улмаас баривчлагдсан, эсхүл саатуулагдсан;</p> <p>70.1.4-т "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон" гэж тус тус заасны дагуу 20.6.6-д заасан этгээдээс санал авах боломжтой мэтээр ойлгогдож байна.</p> <p>Гэтэл 20.6.6-д заасан заалт нь санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тухай зохицуулалт байх бөгөөд 70.1.3, 70.1.4-т зааснаар сонгууль өгөх боломжтой мэт харагдаж байгаа боловч дээрх зохицуулалтад үндэслэн санал авахдаа санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авч байх тул 20.6.6-д заасан зохицуулалтад хамаарах этгээд санал өгөх боломжгүй болох нь тодорхой харагдаж байгаа хэдий ч хуулийн дээрх зохицуулалтууд хэт ойлгомжгүй, алдаатай болохыг харуулж байна.</p> <p>Иймд төслийн 20.6.6-д заасан зохицуулалтыг 20.6-д заасан зохицуулалтаас тусад нь зааглан тусгах, мөн 20.8-д "20.6.4, 20.6.5-д заасан" гэж өөрчлөлт оруулах шаардлагатай.</p> <p>Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-д сонгуулийн хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолохоор зохицуулсан байтал 6.8-д төслийн "Энэ хууль өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална" гэж заасан нь 6.7-д заасан хугацаа тоолох зохицуулалтыг тусгагдаагүй мэтээр ойлгогдоход хүргэж байна. Төслийн 6.8-д энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэж заасан нь 6.7-д заасан заалтыг үгүйсгэж хуулийн зөрчлийг бий болгож байна.</p> <p>Төслийн 45 дугаар зүйлийн 45.2-т сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар</p>
--	---

	<p><i>сурталчилгаа явуулж болох</i> талаар тусгасан бол төслийн 46.4.18-д сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр <i>цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон</i> байна. Иймд эдгээр заалт өөр хоорондоо нийцэхгүй байна.</p>
	<p>Төслийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн тухай заасан байтал 5.2-т эрх хязгаарласан, 5.4, 5.5-д хориглосон зохицуулалт, 5.7, 5.8-д хуулийн санцгийг заасан зүйлийн нэртэй нийцэхгүй байна.</p>
	<p>Төслийн 36 дугаар зүйлийн 36.7-д “төрийн аудитын дээд байгууллага ... бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр энэ хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлтийг санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө гаргана” гэж зааснаас үзвэл бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн талаарх дүгнэлтийг төрийн аудитын дээд байгууллагаас гаргахаар ойлгогдож байна.</p> <p>Харин төслийн 30 дугаар зүйлд нэр дэвшигчийг бүртгэх асуудлыг зохицуулсан бөгөөд 30.3-т “бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ” гэж заасан бөгөөд 30.3.9-д “Энэ хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагаар хянуулсан бие даасан нэрээ дэвшүүлэгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт” гэж заажээ.</p> <p>Өөрөөр хэлбэл, төслийн 36.7, 36.9 дэх хэсэгт “төрийн аудитын дээд байгууллага” гэж, харин 30.3.9 дэх заалтад “төрийн аудитын байгууллага” гэж нэр томъёоны хувьд ялгамжтай байдлаар зохицуулсан нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна.</p> <p>Учир нь Төрийн аудитын тухай хуулийн 6.1-д “Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын дээд байгууллага, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэнэ...” гэж зааснаас үзвэл төрийн аудитын байгууллага нь төрийн аудитын дээд байгууллага болон түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэхээр ойлгогдож байна. Харин тус хуулийн 7.2-т зааснаар “Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага...” юм.</p> <p>Хэрэв төслийн 30.3.9-д заасан уг зохицуулалтыг төрийн аудитын дээд байгууллага бус, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага хэмээн өөр утгаар тайлбарлан ойлговол бие даан нэрээ дэвшүүлэгчийн хувьд нам, эвслээс нэр дэвшиж буй нэр дэвшигчээс ялгамжтай буюу мөрийн хөтөлбөрөө 2 өөр аудитаар хянуулж, Сонгуулийн ерөнхий хороонд аудитын дүгнэлт нь хоёр удаа хүргэгдэнэ гэсэн утгыг илэрхийлэхээр байна.</p> <p>Өөрөөр хэлбэл, төслийн 30.6.9-д заасан заалтад “төрийн аудитын байгууллага” хэмээн хуулийн нэр томъёог хэрэглэснээр төслийн 36.7, 36.9 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэхэд ойлгомжгүй байдлыг бий болгохоор байна</p>
	<p>Төсөлд нийт 55 зүйл, заалтад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль оногдуулахаар заасан байна.</p> <p>/5.7, 6.14, 13.10, 14.18, 14.19, 14.20, 14.22, 19.23, 20.24, 21.9, 22.8, 34.8, 35.4, 37.5, 37.6, 38.5, 39.14, 40.10, 41.3, 42.6, 43.4, 44.22, 45.5, 45.9, 46.12, 46.13, 47.2, 48.6, 50.4, 51.13, 52.4, 53.9, 56.9, 56.10, 56.11, 57.5, 57.6, 63.6, 64.5, 65.4, 69.12, 70.16, 70.17,</p>

	<p>72.14, 72.15, 73.16, 73.17, 74.13, 75.4, 76.6, 77.3, 78.18, 79.6, 80.4, 85.5 дахь хэсэг/ Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль ногдуулахаар төсөлд тусгасан нь хэд хэдэн асуудлыг бий болгож болохоор байна. Тухайлбал, Хууль тогтоогч төсөлд тусгасан торгох шийтгэлийн хэмжээг өөрчлөөгүй байхад Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэр өөрчлөгдвөл уг хуульд заасан торгуулийн хэмжээ өөрчлөгдөхөд нөлөөлж байна. Манай улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийт 12 удаа өөрчлөгдсөн бөгөөд анх тогтоосноос хойш 10.8 дахин нэмэгджээ. Түүнчлэн, хуулийн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг (санкци) хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасан хэдий ч дээрх зүйл заалт бүхэнд давхардуулан зохицуулжээ. 2017 оноос эхлэн дагаж мөрдөгдөх болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудад торгох ял, шийтгэлийг хуульчилж өгсөн байх бөгөөд ийнхүү хуульчлахдаа “нэгж” хэмээх ойлголтыг бий болгож, Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр (Засгийн газрын тогтоолоор) өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм. Иймд төслийн энэхүү зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид хүлээлгэж буй хариуцлагын нэгэн адил, мөн хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасныг өөрчлөн сайжруулж зохих хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй байна.</p> <p>МУИХСтХ-ийн төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй хэлбэр болон агуулгын хувьд давхардсан заалт олон байна. Дэлгэрэнгүйг СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас үзнэ үү.</p>
<p>Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх</p>	<p>Төслийн 4.1 дэх хэсэгт заасан “саналаа нууцаар гаргах” эрхийг 5.6 дахь хэсэгт агуулгын давхардуулан зохицуулсан байна.</p> <p>Төслийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэгтэй хэлбэр болон агуулгын хувьд давхцсан ба үүнтэй холбоотойгоор тус зүйлүүдэд хамаарах санкцийн зохицуулалт мөн давхардсан. Тодруулбал, дурдсан зүйлүүд нь сонгогчийн шууд сонгох эрх болон саналаа нууцаар гаргах эрхийн тухай зохицуулалт бөгөөд тус эрхээ эдлэхэд санаатайгаар саад учруулсан бол 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийг ялгаатай хэмжээний төгрөгөөр торгохоор, 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт заасны дагуу аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заажээ. Иймд нэг үйлдэлд ялгаатай шийтгэл оногдуулахаар зохицуулсан байгааг залруулах, давхардлыг арилгах шаардлагатай.</p> <p>Төслийн “Хууль бус сурталчилгааг хориглох” хэмээх 46 дугаар зүйлд хориглосон үйл ажиллагааг жагсаахдаа мөн зүйлийн 46.1.7, 46.1.9 дэх заалтыг давхардуулан хуульчилсан байна.</p> <p>Төслийн 72 дугаар зүйлийн 72.14, 72.15-д заасан санкцууд хоорондоо давхардсан байна. Учир нь 72 дугаар зүйлийн 72.14-т “Энэ хуулийн 72.12-д заасныг зөрчсөн ... тэнцэх хэмжээний</p>

	<p>төгрөгөөр торгоно”; 72.15-т “Энэ хуулийн 72 дугаар зүйлд заасныг зөрчсөн этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасан. Үүнээс үзвэл, 72 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд бүхэлд нь санкци тогтоосон атлаа 72.12-т хамааруулан дахин тусдаа санкци бий болгосон байна. Иймд энэ давхардлыг засах шаардлагатай.</p> <p>Төслийн 78 дугаар зүйлийн 78.16, 78.17 дахь хэсэг болон 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгүүд нь хоорондоо хэлбэр, агуулгын хувьд давхардсан байгааг засах шаардлагатай.</p>
<p>Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх</p>	<p>Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, <i>танилцуулах</i>, давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ” гэж, мөн зүйлийн 20.23-т “Сонгогчдын нэрийн жагсаалтыг <i>танилцуулах</i> журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтуудаас үзвэл сонгогчдын нэрийн жагсаалт танилцуулах журмыг батлах эрхийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тагнуулын байгууллагад давхардуулан олгосон мэт ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн дээр дурдсан асуудлыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхойгүй байдлаар тусгажээ.</p>
<p>Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэж заасан.</p> <p>Өөрөөр хэлбэл, сонгуулийн эрх бүхий иргэд сонгуульд оролцож санал өгөх эрхтэй. Харин төсөлд “эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон”, “хорих ял эдэлж байгаа” иргэн сонгуульд санал өгөх боломжгүй байдлаар тусгасан.</p> <p>Гэтэл энэхүү төсөлд гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх асуудлыг тусгалгүй орхигдуулсан байна.</p> <p>2002 оны 03 сарын 28-29-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” сэдэвт олон улсын бага хуралд Б.Чимид агсан хэлсэн үгэндээ“... гадаад байгаа манай иргэдийг боломжийн хэрээр оролцуулж болохгүй юу, ялангуяа Улсын Их Хурлын сонгуульд. Олон оронд элчин сайд, консул байгаагийн хэрэг юу юм. Төр, иргэн хоёроо холбохгүй юм бол тэнд дипломат ажил хийж сууна гэж сэтгэл цатгалан байх үндэс байна уу? Ийм хувилбарыг би хуульд тусган боловсруулсан, надад төсөл нь байгаа. Тэнд яаж сонгуулийн хэсэг байгуулах вэ? хэн хариуцах вэ? яаж нэр дэвшүүлэх вэ? гэж. Хэрэв гадаад орон эсэргүүцэхгүй бол элчин сайд, консул байгаа орнуудад Монголын иргэдийг сонгуульд оролцуулах боломж бий”³⁴ гэж үзжээ.</p> <p>Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгдөг. Тэгсэн хэрнээ Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх боломжгүй</p>

³⁴ Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь, Олон улсын бага хурал, УБ., 2002 он, 56 дахь тал.

	<p>байгаа нь учир дутагдалтай. 2016 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажигласан ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар урьдчилсан тайландаа "... нийт 1.912.901 сонгогч 2016 оны сонгууль оролцохоор бүртгэгдсэн. Гадаад улсад суугаа Монгол Улсын 150.000 орчим иргэн ...сонгуульд санал өгөх боломжгүй болж байна³⁵ гэж үзжээ.</p> <p>Дээрхээс дүгнэвэл, гадаад улсад суугаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд Улсын Их Хуралд төлөөлөлгүй болж байна гэсэн үг. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд заасан "сонгох эрх" нь зөрчигдөж байна гэж үзэх үндэслэлтэй.</p>
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	<p>Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага <i>сонгогчдын нэрийн жагсаалт</i> үйлдэх, <i>танилцуулах</i>, давхардлыг шалгах, сонгогч шилжих <i>журмыг</i> энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ" гэж; мөн зүйлийн 20.23-т "<i>Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг</i> улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална" гэж чиг үүргийг давхардуулан хуульчилсан байна.</p>
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	<p>Төслийн 44 дүгээр зүйлийн 44.22-т "...44.11-д заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцална" гэж заасан. Мөн зүйлийн 44.11-д "... шаардлага хангаагүй телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэжээ. ААҮАТЗтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.16-д "Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр" олгох тусгай зөвшөөрлийг мөн хэсгийн 15.16.3-т "контентийн үйлчилгээ эрхлэх" гэж хуульчилсан. Үүнээс үзвэл, төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг ААҮАТЗтХ-д тусгасан гэж үзэж болох боловч нэр томъёоны хувьд ялгаатай байна.</p>
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	<p>Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж болно. Үүнийг сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцохгүй" гэж заасан нь Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд давуу эрх бий болгосон зохицуулалт юм.</p> <p>Өөрөөр хэлбэл, нэр дэвшсэн УИХ-ын гишүүн хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж байгаа нь бусад нэр дэвшигчдээс давуу эрх эдлэн, өөрийн ажлыг тайлагнах замаар сонгуулийн сурталчилгаа хийж буй үйл ажиллагаа гэж ойлгогдож байна.</p>

³⁵ ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар, Сонгууль ажиглах хороо, Монгол Улс. УИХ-ын сонгууль 2016.6.26, Урьдчилсан тайлан /2016 оны 5 сарын 20-оос 6 сарын 14-ний өдөр/.

	Иймд төслийн энэхүү зохицуулалтыг шударга бус өрсөлдөөний бий болгоход чиглэгдсэн заалт гэж үзэх үндэслэлтэй байна.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Төслийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт “Сонгуулийн үйл ажиллагааны явцад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэснийг үзвэл чухам ямар хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй харагдаж байна. Учир нь эдийн болон эдийн бус хохирол учруулсантай холбогдох асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэдэг. Иймд “Иргэний хууль болон бусад хууль” гэж өөрчлөн найруулах. Мөн үүрэгжүүлсэн хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль бусад хуулиар тодорхой тусгах нь зүйтэй юм.
	Төслийн Наймдугаар бүлэг болох Сонгуулийн зардал хэсэгт тусгагдсан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтууд нь гаргасан зөрчилтэй харьцуулахад харьцангуй бага байгаа ажиглагдаж байна. Тухайлбал, төслийн 48 дугаар зүйлийн 48.6-д “Энэ хуулийн 48.3, 48.5-д заасныг зөрчсөн нам, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан бөгөөд торгуулийн хэмжээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр ³⁶ тооцон үзвэл 6.720.000-8.320.000 /зургаан сая долоон зуун хорин мянгаас найман сая гурван зуун хорин мянга/-н төгрөг байхаар байна. Энэхүү зохицуулалтыг сонгуулийн нийт зардлын мөнгөн хөрөнгөд харьцуулж үзвэл хэд дахин бага торгууль оногдуулахаар харагдаж байна. Мөн төслийн 50 дугаар зүйлийн 50.4-т “Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан нь дээр дурдсан төслийн 48 дугаар зүйлийн зохицуулалттай ижил байдлаар ойлгогдож байна. ³⁷

³⁶ "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

³⁷ Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 20 дахь талд “Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна” гэж дурдаж байжээ.

<https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true> (Сүүлд үзсэн огноо: 2019.01.02).

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан билээ. Ийнхүү батлагдсан Сонгуулийн тухай хуулиар 2016 оны ээлжит Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг тус тус зохион байгуулж явуулсан билээ.

2016 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх хийгээд хуулийн алдаа, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил зэргээс үүдэн зохион байгуулалтын явцад ихээхэн хүндрэл бэрхшээл учирч байсныг сонгууль зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, ажиглагч, сонгуульд өрсөлдсөн намын төлөөллүүд илэрхийлсэн байна. Ийнхүү дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн УИХ-ын сонгуулийн харилцааны онцлогийг тусгаж, эрх зүйн орчныг сайжруулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсруулсан хэмээн үзэх үндэслэлтэй.

Хуулийн төслийн олон заалт нь дээр дурдсанчлан Сонгуулийн тухай хуулийн зөрчил, эрх зүйн хийдэл, ойлгомжгүй байдал бий болгож байсан зохицуулалтуудыг боловсронгуй болгож, хүн бүрд ойлгомжтой байдлаар тусган, практикт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн хуулийн төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо давхардсан заалт ихтэй. Мөн МУИХСтХ-ийн төслийн тухайд бусад хууль тогтоомжид заасан хуулийн зүйл, заалт болон төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо давхардсан, зөрчилтэй заалтууд цөөнгүй байна. Энэхүү судалгаагаар МУИХСтХ-ийн төслийн үр нөлөөг үнэлж, шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үзэл баримтлалыг үзвэл гурван зорилт дэвшүүлсэн байх бөгөөд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тодруулбал,

Нэгд, Сонгууль зохион байгуулж явуулах эрх зүйн орчныг сайжруулах;

Хоёрт, “Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах;

Гуравт, “УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах” зорилтын хүрээнд холбогдох зохицуулалтыг сонгон авч үнэлсэн болно.

- Төсөлд СтХ-д заасан зохицуулалтуудыг өөрчлөн найруулж, боловсронгуй болгосон, мөн шинээр зохицуулалт тусгасан зэрэг эерэг нөлөөлөл бүхий зүйлүүд ажиглагдаж байсан ч төслийн зүйл, заалтуудын хоорондын уялдаа холбоо, давхардал, зөрчил хийгээд бусад хуулийн зүйл, заалттай зөрчилдсөн заалтууд олон байсан.
- Төсөлд хэлбэрийн хувьд шинэлэг зохицуулалт цөөнгүй боловч агуулгын хувьд шинэ зохицуулалт ховор байсан тул “хуулийн зорилт” болон “сонгуулийн сурталчилгааны

цахим хуудас"-ны тодорхойлолтыг шинээр томъёолсонтой холбоотой зохицуулалтыг сонгон авсан. Гэвч тийнхүү шинээр томъёолохдоо бусад зүйл, заалтуудын уялдааг нягтлан шалгаагүйн улмаас хуулийн зохицуулалт хоорондын зөрчилтэй байдлыг бий болгож байв. Мөн хуулийн зорилтыг томъёолохдоо зохицуулах харилцааг дутуу томъёолсныг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

- Хууль зүйн шинжлэх ухааны гол ойлголтын нэг нь эрх зүйн зарчим байдаг. Иймд зарчим нь хоосон тунхаг төдий биш бөгөөд аливаа хуулийн зарчим бодитой байх учиртай. Төсөлд сонгуулийн эрх зүйн зарчмыг хуульчлахдаа бүх нийтээр баримтлах түгээмэл зарчмыг хуульчилсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч зарим шаардлагатай зарчим, тодруулбал, "тэгш эрхийн зарчим" болон сонгууль зохион байгуулж явуулах зарчмуудын ихэнхийг нь орхигдуулсан байна.

2. Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн заалтуудаас практикт хэрэгжихэд хүндрэлтэй заалтуудыг сонгон авч судалсан болно. Дээр дурдсан заалт нь СтХ-д ч мөн хуульчлагдсан байдаг бөгөөд 2016 оны Улсын Их Хурлын сонгууль, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас бүрдсэн сонгуулийн ажиглах хороодоос гаргасан тайлан мэдээнд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэр дундаа тэргэнцэртэй иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан сонгох эрхийг хэрхэн хангах талаар судлан үзсэн болно. Төслийн дээрх зохицуулалт нь хуулиар тэргэнцэртэй иргэний сонгох эрхийг баталгаажуулсан, хангахад чиглэгдсэн мэт харагдаж байвч практикт хэрэгжихэд хэд хэдэн асуудлыг үүсгэдэг байна.

Иймд энэхүү зохицуулалтыг практикт хэрхэн хэрэгжүүлбэл зохих талаар судалж, хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгон, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний "сонгох" эрхийг баталгаатай эдлүүлэх боломжийг ханган ажиллах нь зүйтэй.

3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн зохицуулалтууд өөр хоорондоо зөрчилтэй, давхардсан зохицуулалтууд нэлээд олон байгаа нь хуулийн төслийг практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэж, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах боломжтой тул дээр дурдсан зөрчлүүдийг арилгах нь зүйтэй. Тухайлбал,

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэж буй, төслийн зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт хэд хэд байна. Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т хориглосон заалт тусгасан байтал төслийн зарчмын хэсэгт оруулсан, төслийн 46 дугаар зүйлд хориглох заалтууд тусгасан хэдий ч 46.3-т "болно" гэсэн зохицуулалтыг оруулсан, төслийн 20.6 дахь хэсэгт "... ээлжит сонгуулийн жилийн тавдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ" гэж заасан хэрнээ 20.6.6-д "санал авах өдөр зөрчлийн улмаас ... сонгогчдын мэдээллийг" гэсэн зохицуулалтыг оруулсан, мөн төсөлд "итгэмжилсэн ажилтан",

“итгэмжлэгдсэн ажилтан” гэх хоёр өөр нэр томъёогоор нэг хүнийг илэрхийлсэн, мөн явуулах процесс нь өөр байх тохиолдлуудад “нэн даруй” гэсэн ойлголтыг нэгдмэл байдлаар тусгасан байна.

- Төслийн зарим зүйл, заалт нь хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй, зөрчилдөж байна. Тухайлбал, төслийн 16.1, 17.1, 18.1-д заасан зохицуулалтаас үзвэл сонгуулийн хорооны гишүүдийг тэгш тоогоор бүрдүүлж болохоор ойлгогдож байх тул энэхүү асуудлыг нэг мөр болгох нь зүйтэй.

4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 4 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авилга хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 10 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Нэр томъёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томъёотой нийцэхгүй тохиолдол байна. Тухайлбал, ХХТХ-д тусгагдсан “түдгэлзүүлэх” гэснийг “зогсоох” гэж, “хүчингүй болгох” гэснийг “цуцлах” гэж төсөлд өөрөөр томъёолсон байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4 дэх хэсэг нь Төрийн албаны тухай хуулийн “... төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” тухай зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Мөн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “... ажлын арван өдөрт” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Иймд бусад хууль тогтоомжтой зөрчилдөж буй зүйл, заалтуудыг тухайн хууль тогтоомжид нь нийцүүлэн өөрчлөн найруулах нь зүйтэй. Мөн төсөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааруулан торгууль оногдуулахаар заасан нь Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуультай нийцэхгүй байна.
- Хуулийн төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо болон бусад хууль, хуулийн төсөлтэй давхардсан зохицуулалтууд нэлээд байна.³⁸
- Хуулийн төсөлд гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэд УИХ-ын сонгуульд санал өгөх асуудлыг орхигдуулсан гэж үзэж байна.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг тодорхойлохдоо дутуу томъёолсныг өргөжүүлэн зохицуулах;
- Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь заалтад заасан “сонгуулийн сурталчилгааны цахим хуудас”-ын тодорхойлолтыг дахин авч үзэх, зүйл, заалт хоорондын зөрчлийг арилгах;

³⁸ СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- Төслийн 16.1, 17.1-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулахдаа **дарга, нарийн бичгийн даргаас** гадна “таваас долоо”, “гурваас таван” гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар, төслийн 18.1-д хэсгийн хороог **дарга**, зургаагаас найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар зохицуулсан нь сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг тэгш тооны гишүүнтэйгээр бүрдүүлж болохоор ойлгогдож байх тул төслийн 16.1, 17.1, 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг нэг мөр болгох үүднээс 16.1-д “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, 17.1-д “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, 18.1-д “зургаагаас найм гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй;
- Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд анхаарч, хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгох;
- УИХ-ын сонгууль бие даан нэр дэвшиж буй нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлтийн талаар зохицуулсан төслийн 30.6.9, 36.7, 36.9 дэх хэсэгт заасан зохицуулалтыг нэг мөр болгох;
- Бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн төслийн зүйл заалтуудыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулах. Тухайлбал, Төрийн албаны тухай хуульд зааснаар “төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” зохицуулалттай төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг уялдуулах. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан зохицуулалттай төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт заасан зохицуулалтыг уялдуулах;
- Хуулийн төсөлд байгаа хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэж буй зүйл заалтыг нэг мөр болгон цэгцлэх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн зохих шаардлагад нийцүүлэх;
- Хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой төсөлд тусгагдсан зүйл, заалтуудыг нийцүүлэх, харилцан уялдааг сайжруулах;
- Итгэмжилсэн төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх хоёр өөр нэр томъёогоор нэг субъектыг илэрхийлж байгаа өөрчилж, ойлголтыг нэг мөр болгох;
- Төсөлд сонгуулийн санал авах хугацааг “07:00-20:00” болгон өөрчилснийг дахин хянаж, СтХ-д зааснаар “07:00-22:00” болгох;
- Сонгуулийн зардалтай холбоотой төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх талаас нь анхаарах;
- Сонгуулийн тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх зөрчил, эрүүгийн хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тусгайлан хуульчлах;
- Торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бус Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай уялдуулан “нэгж”-ээр торгох тухай зохицуулах шаардлагатай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж,

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 1966
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, 2008
- Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 2003
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №6
- Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
- Төрийн аудитын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2003), №2
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №5
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №8
- Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №4
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24
- Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №1
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), №9
- Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2017 оны 1 дүгээр дүгнэлт “Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”
- Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2016 оны 5 дугаар дүгнэлт “ Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”
- УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий бүтэц, эрхлэх асуудлын хүрээ”
- Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”
- Улсын дээд шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”

Хоёр. Ном, гарын авлага, судалгааны тайлан

- Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ /Хамтын судалгааны тайлан/, УБ., 2015 он.
- Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон Улсын бага хурлын эмхэтгэл, Сонгуулийн ерөнхий хороо, УБ., 2002 он.
- Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000 он.
- Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа. Нийгмийн Бодлого Хөгжил Судалгааны Хүрээлэн. УБ., 2016.
- Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт, Форумын эмхэтгэл, Нээлттэй нийгэм форум, УБ., 2006 он.
- Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу? УБ., 2011 он.
- Б.Чимид, Сонгуульд суралцахуй, УБ., 2008 он.

- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал /хоёр дахь хэвлэл/, УБ., 2017 он.

Гурав. Илтгэл, өгүүлэл, ярицлага, мэдээлэл, лавлагаа /Үсгийн дарааллаар/

- Д.Ганзориг, “Үндсэн хуулийн зөрчил үү, энгийн хуулийнх уу гэдгээс хамаарч маргааныг шийдэх учиртай” (2014.12.26), <http://vip76.mn/content/28970>
- Э.Лхагвасүрэн, “Хариуцлагын механизмыг сонгуулийн хуулинд нарийн тусгах хэрэгтэй” (2014.12.22), <http://vip76.mn/content/28836>
- Б.Чимид, “Сонгуулийн зарчмуудыг зөв хэрэгжүүлэхүй” (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл
- Ж.Ядамсүрэн, “Монгол Улсын сонгуулийн тогтолцоо, зарчмыг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь ардчиллын нэг ололт мөн” (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл

Дөрөв. Цахим эх сурвалж

- Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас <http://www.aweb.org/eng/main.do>
- Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас <http://asianelectionauthorities.org/index.html>
- Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудас <http://гec.gov.mn/>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <http://www.legalinfo.mn/>
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас <http://www.nli.gov.mn/>
- Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлэг <http://vip76.mn/forum/40>
- Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль 2017 оны 6-р сарын 26-ны өдөр <https://www.osce.org/mn/odhr/327166?download=true>
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6 сарын 26 болон 7 сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан <https://www.osce.org/mn/odhr/elections/mongolia/366136?download=true>